

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/01

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг болон 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэсэн Хөвсгөл ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/02

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ХУВЬЦААНЫ ҮСГЭН КОД ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1, 62.1.1, 62.1.15, 62.1.16 дахь хэсэг 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “ХӨВСГӨЛ” ХК-ийн оноосон нэрийг **“И АЙ ТИ” ХК** болгон өөрчилсүгэй.
2. Компанийн оноосон нэр өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор эрх бүхийн байгууллагын зөвшөөрөл олгогдсоны дараа одор тутмын сонинд зарлуулсугай.
3. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусган дүрмийн шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор баталсугай.
4. Компанийн оноосон нэрийн өөрчлөлтийн зөвшөөрлийг холбогдох төрийн эрх бүхий байгууллагаас авч, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.
5. Компанийн оноосон нэрийг өөрчилсөнтэй холбоотойгоор компанийн хувьцааны арилжаанд хэрэглэгддэг үсгэн код /тикер/ болох **“HVL”**-ийг **“EIT”** болгож өөрчилсүгэй.
6. Хувьцааны үсгэн кодын өөрчлөлтийг Арилжаа эрхлэх байгууллага, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/03

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН БҮРТГЭЛТЭЙ ХАЯГИЙГ ӨӨРЧЛӨХ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ШИНЭЭР АВАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн бүртгэлтэй хаягийг “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал Тауэр, 17 давхар” болгон өөрчилсүгэй.
2. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусган дүрмийн шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор баталсугай.
3. Компанийн бүртгэлтэй хаягийг орон нутгаас Улаанбаатар хот дахь хаягт шилжүүлэн бүртгүүлэхтэй холбоотойгоор Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/04

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн эрхлэх үндсэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар өөрчилсүгэй:
 - Менежментийн зөвлөгөө өгөх
2. Компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг тусган дүрмийн шинэчилсэн найруулгыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор баталсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/05

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТАЛСУГАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийг хуульд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад бүртгэх ажилд хяналт тавьж холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/06

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд доор дурдсан нэр бүхий гишүүдийг сонгон, томилсугай. Үүнд:


Ердийн гишүүд:

1. Галням Уянга
 2. Чулуунбаатар Хандаа
 3. Жаргалсайхан Алтангүний
 4. Ганхуяг Сэлэнгэ
 5. Отгонбаяр Амарболд
 6. Цэрэнжав Тайшир
- Хараат бус гишүүд:

1. Цоодол Эрдэнэчимэг
2. Пунцагпэрэн Оюун
3. Цогбадрах Батбаяр

2. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Р.Дулмаад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА

ХӨВСГӨЛ ХК

2022 оны 04 сарын 29

№ 22/07

Улаанбаатар хот

“ХӨВСГӨЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

КОМПАНИЙН БҮРТГЭЛТЭЙ АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 22/01 тоот Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоол, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК-ийн бүртгэлийн урьдчилсан дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хөвсгөл” ХК-ийн Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-тай байгуулсан Бүртгэлийн гэрээг цуцалж, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК-тай Бүртгэлийн гэрээ байгуулах, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
2. Бүртгэлийн гэрээг шинэчлэн байгуулах, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагыг өөрчлөхтэй холбогдсон нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, бүртгэл шилжихэд шаардлагатай ажлыг холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээний актад нийцүүлэн зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.УЯНГА